



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 676

танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БУГАТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн С.Лхагважаргалын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021357

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн С.Лхагважаргал Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн С.Лхагважаргалын мөрийн хөтөлбөр (.....*л*.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн С.Лхагважаргалд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ С.ЛХАГВАЖАРГАЛЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

1.1 Хөдөө аж ахуйн бодлого

- 1.1.1 Малчдыг хоршооны үйл ажиллагаа эрхлэх, нөхцөл боломжийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Малын үүлдэр угсааг сайжруулах бодлогыг дэмжинэ.
- 1.1.3 Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 1.1.4 Иргэдийн ногоон тэжээл тариалах үйл ажиллагааг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2 Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний бодлого

- 1.2.1 Жижиг бизнес эрхлэх иргэдийг бодлогоор дэмжинэ.
- 1.2.2 Худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, түүний аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг тогтмолжуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.3 Дэд бүтэц

- 1.3.1 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчлийг арилгах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.2 Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4 Төсөв санхүүгийн чиглэлээр

- 1.4.1 Сумын төсөв, түүний төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг олон нийтэд нээлттэй санал асуулгаар явуулах, гүйцэтгэлд иргэд хяналт тавих бодлогыг хэрэгжүүлнэ.


1.5 Нутгийн захиргааны ажил үйлчилгээ

- 1.5.1 Сумын хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг бодлогоор дэмжинэ.
- 1.5.2 Төрийн албан хаагчдыг тогтвор сууршилтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, залуу албан хаагчдыг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

1.6 Эрүүл мэндийн бодлого

- 1.6.1 Эрүүл мэндийн анхан шатны болон харийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрт илрүүлэгт багийн иргэдийг хамруулах бодлогыг баримтлана.
- 1.6.2 Цэцэрлэг, сургуулиудын хүүхдүүдийн шүд амны хөндийг эрүүлжүүлэх, иргэд, малчдыг мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.7 Боловсролын бодлого



- 1.7.1 Спортын болон урлагийн авьяастай хүүхдүүдийн авьяасыг нээн илэрүүлэх, сурталчлан таниулах бодлогыг барина.
- 1.7.2 Сургуулийн хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:



/С.ЛХАГВАЖАРГАЛ/ 99316632

